



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/187

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн
гэрчилгээ шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2021 оны 269 дүгээр тогтоол, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Хөвсгөл аймгийн цөм сүргийн үржлийн төв (8179565)-ийн хүсэлтийн дагуу Мөрөн сум 7 дугаар багт байршилтай 6712014705 нэгж талбарын дугаартай 4300м² аж ахуйн зориулалттай газрыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (9070656)-т үлдсэн 25 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан Мөрөн сумын Засаг даргын 2007 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн №28 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 7 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (9070656)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН